



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/409

Мандалговь

Зардал гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 16 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ковид-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд түргэвчилсэн оношлуур худалдан авахад 32,000.000 (Гучин хоёр сая) төгрөгийн, Сайнцагаан суманд үүссэн малын гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэмийн эргүүл постны албан хаагчдын хоол, хүнсний зардалд 3,412.111 (Гурван сая дөрвөн зуун арван хоёр мянга нэг зуун арван нэгэн) төгрөгийн зардлыг тус тус гаргасугай.

2. Зардалд шаардагдах 35,412.111 (Гучин таван сая дөрвөн зуун арван хоёр мянга нэг зуун арван нэгэн) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210563